



МОНГОЛ УЛС: ХҮНИЙ ЭРХИЙН БАЙДЛАА САЙЖРУУЛАХЫН ТУЛД ИЛҮҮ ИХИЙГ ХИЙХ ЁСТОЙ

НҮБ-ЫН ЭЭЛЖИТ ДҮГНЭЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛЭЭС ИЛГЭЭХ МЭДЭЭЛЭЛ
ЭДХ-ИЙН АЖЛЫН ХЭСГИЙН 36 ДУГААР ХУРАЛДААН, 2020 ОНЫ 11 САР

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнл нь хүн бүр эрхээ эдэлдэг дэлхийн ертөнцийг бий болгохын төлөө 7 сая гаруй гишүүд, дэмжигчдийг эгнээндээ нэгтгэсэн даян дэлхийн хөдөлгөөн юм.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон хүний эрхийн олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан бүхий л эрхийг хүн бүрд эдлүүлэх нь бидний эрхэм зорилго билээ.

Бид төр засгийн аливаа байгууллага, улс төрийн үзэл хандлага, эдийн засгийн эрх ашиг болон шашны үзлээс бүрэн ангид, хараат бус байгууллага бөгөөд гишүүд дэмжигчид хийгээд олон нийтийн хандив, дэмжлэгээр санхүүждэг болно.

©Эмнести Интернэшнл 2019

Энэ сэтгүүлд тусгагдсан бүтээлүүд Бүтээлч Хамтын Өмчид харьяалагдана. (зохиогчийн нэрийг дурдана, худалдахгүй, хуулбарлахгүй, олон улсын 4.0 зөвшөөрөл)

<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудсаас авна уу:

www.amnesty.org

Зохиогчийн эрхийг Эмнести Интернэшнл хэмээн заагаагүй тохиолдолд

Бүтээлч Хамтын Өмчийн зөвшөөрөл олгохгүй.

2019 онд анхлан хэвлэв.

Amnesty International Ltd

Ийстон Гудамж 1, Петер Бененсоны Ордон

Лондон хот WC1X 0DW, UK

Индекс: ASA 30/1297/2019

2019 оны 10 сард хэвлэж, 2020 оны 7 сард шинэчлэв.

Эх хэвлэлийн хэл: Англи

amnesty.org

АГУУЛГА

| | |
|---|----|
| ТАНИЛЦУУЛГА | 4 |
| ӨМНӨХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДАРААХЬ АРГА ХЭМЖЭЭ | 4 |
| ЦААЗААР АВАХ ЯЛ | 4 |
| ЭРҮҮДЭН ШҮҮХ БА БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА | 4 |
| ХҮНИЙ ЭРХИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ НЬ | 5 |
| ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО | 5 |
| ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ | 5 |
| ХҮНИЙ ЭРХИЙН БОДИТ БАЙДАЛ | 6 |
| ЭРҮҮДЭН ШҮҮХ БА БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА | 6 |
| ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХ | 7 |
| ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН БУСАД ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТ | 8 |
| ХАЛДЛАГА, АЙЛГАН СҮРДҮҮЛЭЛТ, ЗАНАЛХИЙЛЭЛД ӨРТӨЖ БҮЙ ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД ДҮР ЗОРГООР ХОРИХ | 8 |
| ЗӨВЛӨМЖ | 9 |
| ХАВСРАЛТ | 11 |

ТАНИЛЦУУЛГА

Энэ мэдээллийг 2020 оны 5 дугаар сард Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцэх Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэг (ЭДХ)-т зориулан анхлан бэлтгэсэн. КОВИД-19 цар тахлын улмаас уг хэлэлцүүлэг 2020 оны 11 дүгээр сар хүртэл хойшлогдсон тул энэ мэдээллийг 2020 оны 7 дугаар сард шинэчиллээ. Үүнд Эмнести Интернэшнлээс цаазаар авах ял, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаа, хүний эрхийн гэрээ конвенцийг соёрхон батлах асуудлаар өмнөх ЭДХ-ээс Монголд Улсад өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэлээ.

Мөн шүүхийн хараат бус байдалтай холбоотой хүний эрхийн тогтолцоог үнэлсэн.

Хүний эрхийн бодит байдалтай холбоотойгоор эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаа, орон байртай байх эрх, эдийн засаг нийгэм соёлын эрх, хүний эрх хамгаалагч, дур зоргоор хорих тухайд санаа зовоох асуудал байгааг Эмнести Интернэшнл онцоллоо.

ӨМНӨХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДАРААХЬ АРГА ХЭМЖЭЭ

Монгол улс 2015 онд НҮБ-ын гишүүн улс орнудаас Ээлжит II Дүгнэлт Хэлэлцүүлгээс өгсөн 164 зөвлөмжөөс 150-ыг хүлээн авч 14-ийг нь татгалзсан.¹

ЦААЗААР АВАХ ЯЛ

Сүүлийн хэлэлцүүлгээс хойш Монгол улс 2015 оны 12 дугаар сард Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг батлах зэргээр хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулах хэд хэдэн санаачилгыг эхлүүлсэн. 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан.² Гэвч Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 онд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг сэргээх оролдлого гаргасанд Эмнести Интернэшнл харамсаж байна.³

ЭРҮҮДЭН ШҮҮХ БА БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Засгийн газар эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцахтай тэмцэх тухай зөвлөмжүүдийг хүлээн авсан. Эдгээр зөвлөмжид эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан

¹ Report of the Working Group on the Universal Periodic Review, Mongolia, paragraph 108.1-108.164, 13 July 2015, A/HRC/30/6 and Report of the Working Group on the Universal Periodic Review, Mongolia, Addendum, pages 2-3, A/HRC/30/6/Add.1, 16 September 2015.

² A/HRC/30/6, paragraph 108.3, and A/HRC/30/6/Add.1, pages 2-3.

³ President of Mongolia Khaltmaagiin Battulga, *President Battulga to present to parliament draft bill on reinstating capital punishment for child sexual abuse offenses*, 2 April 2018, president.mn/en/2018/04/02/president-battulga-to-present-to-parliament-draft-bill-on-reinstating-capital-punishment-for-child-sexual-abuse-offenses/

сэргийлэхтэй холбоотой сургалтыг төрийн албан хаагч, шүүгч, хуульчдад явуулах,⁴ Эрүүгийн хуульдаа эрүүдэн шүүхийн талаарх тодорхойлолтыг нэмж,⁵ зэргээр үр нөлөө бүхий мөрдөн шалгах механизм бий болгох, эрүүдэн шүүх болон зүй бус харьцах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой арга хэмжээнүүдийг бэхжүүлэх, цагдаа болон, бусад төрийн албан хаагчийн үйлдсэн хүчирхийллийн бүх гэмт хэрэгт хараат бус, бүрэн гүйцэд мөрдөн шалгах ажиллагаа явуулахаа баталгаажуулах тухай багтсан байв.⁶ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга анх удаагаа Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенци (ЭШЭК)-д заасан тодорхойлолтыг өргөн хүрээнд тусгаж өгсөн ба эрүүдэн шүүх гэмт хэрэгт аливаа байдлаар хамтран оролцсон этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах тухай тусгаж өгсөн.⁷ Харамсалтай нь засгийн газар 2015 оны 2 дугаар сард Монгол улсад үүрэг болгосон эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцсан хэрэгт нэн даруй, шударга мөрдөн шалгах ажиллагаа явуулах гомдлын механизм бий болгох, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол (ЭШЭКНП)-ын 20-р зүйлд заасан механизмд хандах боломжоор хангах асуудлаар ажилласангүй.

Мөн Засгийн газар ЭШЭК-ийн 21, 22 дугаар зүйлд заасан хувь хүний мэдээллийг хүлээн авах тухай Эрүүдэн Шүүхийн эсрэг Хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдэх тухай зөвлөмжийг хүлээн авахаас татгалзсанд Эмнести Интернэшнл харамсаж байна.⁸

ХҮНИЙ ЭРХИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ

Бүх цагаач ажилчид, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц, 1951 оны Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенц, түүний 1967 оны Протоколыг соёрхон батлах тухай зөвлөмжийг хүлээн авахаас татгалзсанд Эмнести Интернэшнл харамсаж байна.⁹

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

2019 онд Монгол Улсын Их Хурлаас Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Прокурорын тухай хууль, Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын даргаас бүрдсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчид, ерөнхий прокурор, түүний

⁴ A/HRC/30/6, recommendations 108.26-27 (Morocco, Mexico), 108.35 (Pakistan), 108.71 (Mexico), 108.80 (Costa Rica).

⁵ A/HRC/30/6, recommendation 108.74 (Hungary).

⁶ A/HRC/30/6, recommendations 1008.72-73 (Czech Republic, France), 108.75-79 (Austria, Timor-Leste, Switzerland, Sweden, Italy).

⁷ United Nations Human Rights Office of the High Commission (OHCHR), *Committee against torture considers report of Mongolia*, 3 August 2016, ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=20332&LangID=E.

⁸ A/HRC/30/6, recommendations 108.4-6 (Algeria, Poland, Denmark).

⁹ A/HRC/30/6, recommendations 108.9-108.16 (Paraguay, Uruguay, Algeria, Philippines, Indonesia, Sierra Leone, Norway, Canada).

орлогчид, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нарыг ажлаас чөлөөлөх зөвлөмж гаргах эрхийг олгож байна. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь шүүгчдийн шийдвэрүүдийг улс төржүүлэх эрсдэлд оруулж, улмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлж, хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх эрхэд аюул учруулж байна.

НҮБ-ын хүний эрх хамгаалагчийн асуудлаарх Тусгай Илтгэгч “эрх мэдлийн хувиарлалтыг улам дордуулах, шүүхийн хараат бус байдлыг ноцтойгоор алдагдуулах, эрх мэдлийн хянал тэнцлийг үгүйсгэсэн, авлигал, ял завшихтай тэмцэх шүүхийн чадавхийг хязгаарлана” хэмээн энэ өөрчлөлтийн талаар зовинолоо илэрхийлсэн.¹⁰

Энэ нэмэлт өөрчлөлтийн улмаас 2019 оны 6 дугаар сарын 26-нд 17 шүүгчид, ерөнхий шүүгчдийн бүрэн эрхийг түдгэлзүүлсэн байна.¹¹ 2020 оны 6 дугаар сарын 24-нд болсон Парламентын сонгуулиас нэг сар орчмын өмнө 5-р сарын 20-нд Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгчийг өөрчилжээ.¹²

ХҮНИЙ ЭРХИЙН БОДИТ БАЙДАЛ

ЭРҮҮДЭН ШҮҮХ БА БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд заасан хараат бус, чиглэсэн мөрдөн шалгах механизм дутагдаж байгаагаас саатуулагдсан хүмүүсийг эрүүдэн шүүж, зүй бус харьцсан хэргийг мэдээлэхгүй байх, ял завших явдал үргэлжилсээр, улам нэмэгдэж байна.

2017 оны 7 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүдэн шүүх болон эрүүдэн шүүж авсан мэдүүлгийг шүүх ажиллагаанд нотлох баримт болгож ашиглахыг илт хориглосон. Хэдий тийм боловч иргэний нийгмийн байгууллагуудын уриалга, нөлөөллийг үл харгалзан татан буулгасан Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах тусгай албыг дахин байгуулах тухай тусгаж өгөөгүй. Засгийн газар мөн эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцсан хэргийн бүх хохирогч эрхээ бүрэн нөхөн сэргээлгэх, хохирлоо нөхөн төлүүлдэг байхыг баталгаажуулсангүй.

2015 оны 2-р сарын 12-нд Монгол улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орсон ч өнөөг хүртэл Урьдчилан Сэргийлэх Үндэсний Механизм (УСҮМ) байгуулах үүргээ биелүүлсэнгүй. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нь Комисст УСҮМ байгуулах эрхийг олгож байгаа ч уг хуульд энэ механизм ба түүний гишүүдийг сонгох процесс хэт ерөнхий, тодорхой бус тусгагдсан байна. 2019 оны 9 дүгээр сарын байдлаар уг хуулийн төсөл парламентаар хэлэлцүүлэгдэхээр хүлээгдэж байлаа. Эрүүдэн шүүсэн хэргийг мөрдөн шалгах хараат бус алба, урьдчилан мэдэгдэлгүйгээр бүх төрлийн хорьж, саатуулах газарт нэвтрэх эрх бүхий УСҮМ дутагдаж байгаа нь эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаа, ялангуяа мэдүүлэг авахын тулд эрүүдэн шүүх явдал гарсаар байхад нөлөөлж байна.

2019 оны 3 дугаар сарын 21-нд Хууль зүй, дотоод хэргийн сайд хэрэг хүлээлгэхийн тулд эрүүдэн шүүсэн хэрэг гарсанд Засгийн газрын өмнөөс уучлал хүсч байгаагаа мэдэгдсэн.¹³

¹⁰ Visit to Mongolia, 30 April – 13 May 2019 - End of mission statement by United Nations Special Rapporteur on the situation of human rights defenders Michel Forst.

¹¹ President of Mongolia Khaltmaagiin Battulga, “President suspends some Chief Justices and other court judges”, 26 June 2019. president.mn/en/2019/06/26/president-suspends-some-chief-justices-and-other-court-judges/

¹² President of Mongolia Khaltmaagiin Battulga, 20 May 2020. president.mn/14518/

¹³ *Tortured to Confess: video of interrogation by Mongolian intelligence officers released*, NewsMN, news.mn/en/787057/.

Үүний дараа 3 дугаар сарын 29-нд засгийн газар УИХ-ын гишүүн асан, Ардчилсан намын манлайлагчдын нэг С.Зоригийг алсан хэргээр 24-25 жилийн хорих ял сонссон Б.Содномдаржаа, Т.Чимгээ нарын хэрэгтэй холбоотой видеог олон нийтэд дэлгэсэн.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх тухайд хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг сургах алхам хэрэгжүүлснийг эс тооцвол эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, хоргодох байрны үйлчилгээ үзүүлэгч, асрамжийн газрын ажилтан, цэргийн бие бүрэлдэхүүн зэрэг бусад мэргэжилтнүүдийг сургах асуудал дутагдаж байна. Сүүлийн жилүүдэд эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаатай холбоотой тагнуулын газрын ажилтнууд, цэргийн бие бүрэлдэхүүн, цагдаагийн эсрэг хэд хэдэн гомдлууд гарсан. Гэвч эдгээр хэргийн мөрдөн шалгах ажиллагаа болон шүүх ажиллагааны үр дүнгийн талаар олон нийтэд дэлгэсэн мэдээлэл байхгүй байна.

ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХ

Агаарын болон хөрсний бохирдол, өвлийн улиралд бий болдог өтгөн утааг бууруулах зорилгоор 2017 онд Улаанбаатар хотын захиргаанаас хөдөө орон нутгаас шилжин ирэх шилжилт хөдөлгөөнийг хориглосон.¹⁴ Үүний уршигаар, дотоодын шилжин суурьшигчид хууль бусаар гэр хороололд нүүж ирцгээсэн.¹⁵ Гэр хороолол нь нийгмийн болон инженерийн дэд бүтэц зам, ус, ариун цэврийн байгууламж, халаалт зэрэгт бүрэн холбогдоогүй гэр, байшин бүхий газрыг хэлнэ. Гэр хороололд шилжин ирсэн энэ хүмүүс засаг захиргааны анхан шатны нэгж (хороо)-дээ бүртгүүлэх боломжгүйгээс нийгмийн үйлчилгээ хүртдэггүй.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн ч холбогдох эрх зүй, бодлогууд хожимдож байна. Хот байгуулалтын тухай хууль 2008 онд батлагдсан бол Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг 2015 онд л баталжээ.¹⁶ Энэ хоёр хууль болон дагалдах журмууд нь хүний эрхийн талаарх олон улсын хууль, хэм хэмжээтэй нийцэхгүй байна.

Тодорхой, шаардлага хангасан төрийн зохицуулалт, үр дүнтэй санал солилцох явц байхгүй, хяналт тавиагүй нь дахин төлөвлөлтөд хамрагдаж буй иргэдийн эрхийг төрөл бүрээр зөрчих эрсдэл бий болгож, ялангуяа шаардлагад нийцсэн орон байртай байх эрх зөрчигдөхөд хүргэсэн гэж Эмнести Интернэшнлийн 2016 оныхоо судалгаанд онцолсон. Одоогийн хууль, эрх зүйн зохицуулалт нь хүний эрхийн талаарх олон улсын эрх зүй, хэм хэмжээний дагуу Монгол Улсын төрөөс иргэдийнхээ эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх талаар хүлээсэн үүрэгтэй нийцэхгүй байгаа бөгөөд олон оршин суугчдыг орон гэрийнх нь асуудал яаж шийдэгдэхийг мэдэхгүй хүлээх эрсдэлд оруулж байна.¹⁷

Хүн амынхаа шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хамгаалахын тулд Монгол Улсын Засгийн газар энэ эрхийг зөрчих аливаа үйлдлээс зайлсхийх, зогсоохоос гадна, уг эрхийг хашаа, байр түрээслүүлэгч, хувийн барилгын компани зэрэг гуравдагч этгээд зөрчихөөс хамгаалах ёстой.¹⁸ Гэвч Засгийн газар эдгээр асуудалд анхаарал хандуулсангүй.

¹⁴ The city Governor and Ulaanbaatar Mayor's decree A/17 on the "Measures to be taken in connection with the right to a healthy and safe environment" of the 9th of January 2016.

www.ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=20665; Amendment to the Decree A/1042 of the 27th of December 2017 to extend the Ulaanbaatar migration ban until the 1st of January 2020. www.ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=28132

¹⁵ Ger is traditional round felt dwelling used by nomadic herders in Mongolia.

¹⁶ Urban Redevelopment Law, passed by the Mongolian Parliament On 26 June 2015; unofficial English language translation on file at Amnesty International.

¹⁷ Amnesty International, *Falling Short- The right to adequate housing in Ulaanbaatar, Mongolia* (Index: ASA 30/4933/2016)

¹⁸ Amnesty International, *Falling Short- The right to adequate housing in Ulaanbaatar, Mongolia* (Index:

Дахин төлөвлөлтийн талаарх шинэчлэгдсэн мэдээллээр хангагдахгүй, дахин төлөвлөлтийн улмаас нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүст зохих нөхөн олговор олгогдохгүй, нөлөөлөлд өртсөн хүмүүстэй бодитоор зөвлөлдөхгүй байгаагаас үүдэн оршин суугчид албадан нүүлгэгдэх эрсдэл дунд амьдарч байна.

Дахин төлөвлөх шийдвэр гарсан хуучны байранд амьдарч байсан П.Давааням болон 11 хүнийг төсөл хэрэгжүүлэгч компани нь 2019 оны 4 дүгээр сарын эхээр хүчээр албадан нүүлгэснээс болж орон гэргүй болжээ. Ам бүл арвуулаа П.Даваанямынх одоо байр түрээслэн амьдарч байна.

Хөндөгдсөн эрхийг сэргээх талаар хууль, журам, бодлого нь ойлгомжгүй, дахин төлөвлөлтөд өртөн хохирсон иргэдэд гомдол гаргах, маргаан шийдвэрлүүлэх сонголтыг тодорхой зааж өгөөгүй байна. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдсөн Зөрчлийн тухай хуулиар хувь хүн болон бизнесийн байгууллагын нэр хүндэд халдсан хэргээр торгууль ногдуулах нь ихэссэн байна. Дахин төлөвлөлтөд хамрагдсан иргэд олон нийтийн сүлжээ ашиглан бодитоор зөвлөлдөх эрхээ эдлэж, мэдээлэл нийтлэж, солилцсоных нь төлөө төсөл хэрэгжүүлэгч хувийн компаниуд Зөрчлийн тухай хуулийг иргэдийн эсрэг ашиглаж байна.

Шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хамгаалсан хүний эрхийн идэвхтнүүдийг төсөл хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн компани Зөрчлийн тухай хуулиар шүүхэд өгөх эрсдэл байна. Хууль сахиулагчид, хувийн корпорацуудтай холбоотой хүмүүс бие махбодийн дайралт, дарамт шахалт үзүүлсээр байгаа гэж идэвхтнүүд мэдээлсээр байна.¹⁹ Дахин төлөвлөлтийн талаар оршин суугчиддаа мэдээлэл өгч, тэднийг төсөл хэрэгжүүлэгч компаний хууль бус бүх үйлдлийг эсэргүүцэн үзэл бодлоо илэрхийлэхэд хүргэсэн, орон байртай байх эрхийн идэвхтнийг цагдаагийн газраас мэдүүлэг авах зорилгоор байнга дууддаг байна. Түүнийг Засгийн газрын зөвшөөрөлтэй үйл ажиллагааг тасалдуулсан хэрэгт буруутгажээ. Орон байртай байх эрхийн төлөөх кампанит ажлаас нь болж түүнийг төрийн албан хаагчийн ажлаас нь халсан аж.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН БУСАД ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт овоорон ажиллах уул уурхайн компаниуд, тэдний ачааг тээвэрлэх машинуудын асар их шороо, тоос нь малын бэлчээрийг доройтуулж, хүн, малын эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлж байна. Цэвэр ус, газар, бэлчээр ашиглах, эзэмших болон уламжлалт өв соёл, амьжиргаанд нь сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компанийн үйл ажиллагаанаас эрх баригчид малчдыг хамгаалж чадсангүй. Уул уурхайн нэгэн компани иргэд амьдардаг суурьшлын бүсэд хорт хаягдал хаясны улмаар иргэд хордсон талаарх гомдол, мэдээллийг Эмнести Интернэшнл 2017 онд хүлээж авсан. Хортой хог, бохирдлын тухай дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд ил болгуулахгүй байхаар уул уурхайн компаниуд Завхан аймгийн Дөрвөлжин сумын малчдыг айлган сүрдүүлж буй талаарх гомдлыг Эмнести Интернэшнл мөн хүлээж аваад байна.

ХАЛДЛАГА, АЙЛГАН СҮРДҮҮЛЭЛТ, ЗАНАЛХИЙЛЭЛД ӨРТӨЖ БҮЙ ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД

Монголд байгаа хүний эрх хамгаалагчид олон түвшинд халдлагад өртөж байна. Засгийн газрыг дэмжигчид тэднийг “таагүй этгээд”, “төвөг удагч”, “гадаадын гар хөл”, “хөгжлийг гацаагч” гэх зэргээр нэрлэж, хочилдог. Засгийн газар төрийн бус тоглогчдын зүгээс ирж буй халдлага, заналхийллээс хүний эрх хамгаалагчдыг хамгаалж чадсангүй.

ASA 30/4933/2016)

¹⁹ Amnesty International, *Amnesty International Report 17/18* (Index: POL 10/6700/2018)

Хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаагаа явуулахдаа шаардлагатай байгаа мэдээлэл, сүлжээ, арга хэрэгслийг авч чадахгүй элдэв хязгаарлалт, бэрхшээлүүдтэй тулгарч байна. Тоног төхөөрөмжийг нь эвдэж, нууц эх сурвалжаа илчлэхийг шаардсан тухай зарим сэтгүүлч мэдээлсэн.

Хүний эрх хамгаалагчдыг ялгаварлан гадуурхсан; дарамталсан; цагдаа болон бусдын зүгээс айлган сүрдүүлсэн; гутаан доромжилсон гэх мэдээллийг Эмнести Интернэшнл хүлээн авсан. Орон байртай байх эрхийн төлөөх идэвхтнүүд, сэтгүүлчид, байгаль орчны идэвхтнүүд, цахим орчинд үзэл бодлоороо манлайлагчид руу дугаараа нууцалсан утаснаас залган үйл ажиллагаагаа зогсоохыг шаардах зэргээр дарамталжээ. Байгаль орчны идэвхтнүүд, сэтгүүлчид цагдаа нар тэднийг айлган сүрдүүлж, заналхийлсэн тухай мэдээлсэн.

Халдлага үйлдэгчдийг барьж хариуцлага тооцох механизм, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах цогц хамгаалалт дутагдаж байгаа нь тэднийг дарамталсан, айлган сүрдүүлсэн хэрэгт ял завшуулж байна. Засгийн газар Хүний эрх хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэж байна.

Одоогийн хуулийн төсөл нь эрх зүйт ёсыг дордуулах, цаашид иргэний нийгмийн орон зайг хумих эрсдэлтэй байна. Тухайлбал Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бүртгэл болон гадаадын санхүүжилтэд тавих хяналтыг илүү чангатгасан нөхцлийг оруулсан. Засгийн газар “мөнгө угаахтай тэмцэх, гадны санхүүжилтийг хязгаарлаж, гадаадын нөлөөллөөс зайлсхийхэд ТББ-ын тухай хуульд энэ нэмэлт өөрчлөлтийг оруулах хэрэгтэй байна” гэж тайлбарласан.²⁰

ДҮР ЗОРГООР ХОРИХ

Монгол Улсад 6 дугаар сард болсон Парламентын сонгуулийн өмнө олон шалтгаанаар, үүний дотор эрх баригчдыг цахим болон цахим бус орчинд шүүмжилсэн мөн улс төрийн бусад шалтгаанаар баривчлагдан, хоригдсон хүмүүсийн тоо нэмэгджээ.

Олны танил Даваадоржийн Ганболд (1990-1992 онд Засгийн газрын Тэргүүн шадар сайдаар ажиллаж байсан), Мэндсайханы Энхсайхан (1996-1998 онд Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан), Жаргалтулгын Эрдэнэбат (2016-2017 онд Ерөнхий сайдаар ажиллаж байсан) зэрэг хүмүүс хоригдсон.²¹ Шударга шүүхийн олон улсын хэм хэмжээнд нийцээгүй шүүх ажиллагааны улмаас 2020 оны 7 дугаар сарын 20-ны байдлаар тэднийг хорьсоор байв.²²

Эмнести Интернэшнл Монгол улс дахь авлигал, хүний эрхийн нөхцөл байдлыг шүүмжилснийхээ улмаас ТББ-ын тэргүүнүүд, хуульчид хоригдсон тухай мэдээллийг хүлээн авсан. Тус мэдээлэлд дурдсанаар тэднийг ямар нэг шүүх ажиллагаа явуулалгүйгээр хэдэн долоо хоног хорьсон байна.

²⁰ OHCHR, *Visit to Mongolia, 30 April – 13 May 2019- End of Mission Statement*, www.ohchr.org/en/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=24603&LangID=E

²¹ Mongolian News Agency, “Has court breached former Prime Minister’s parliamentary immunity?” 18 June 2020. montsame.mn/en/read/228921

²² News.mn, “Former Mongolian PM imprisoned!”, 7 May 2020. news.mn/en/792285/ and “More candidates imprisoned ahead of Mongolian parliamentary election” 18 June 2020. news.mn/en/793036/

ЗӨВЛӨМЖ

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛЭЭС МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХАНДАН УРИАЛЖ БАЙНА. ҮҮНД:

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- Бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан байдлаа үргэлжлүүлэн баталгаажуулах;
- Бүх цагаач ажилтан, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц, 1951 оны Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенц, түүний 1967 оны Протоколыг соёрхон батлах;
- Шүүхийн хараат бус байдал, прокурорын бие даасан байдлыг баталгаажуулах бодит арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх.

ЭРҮҮДЭН ШҮҮХ БА БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

- Мөрдөн байцаагч, эрүүдэн шүүгчдийн хооронд байгууллагын эсвэл албан тушаалтны оролцоогүйгээр аливаа хууль сахиулагч оролцсон эрүүдэн шүүсэн, зүй бус харьцсан бүх мэдүүлэг, гомдлыг хараат бус механизмаар яаралтай, үр дүнтэй, шударгаар мөрдөн шалгаж, хариуцлага хүлээлгэхээ баталгаажуулах;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт Протоколд заасанчлан үр нөлөө бүхий Урьдчилан Сэргийлэх Үндэсний Механизм яаралтай байгуулах;
- Эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцааны хохирогчид олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд заасны дагуу шаардлагад нийцсэн, шударга нөхөн олговор авах, нөхөн сэргээлгэх зэргээр хохирлоо барагдуулах эрхтэй байхыг баталгаажуулах яаралтай арга хэмжээ авах;
- Шүүгч, прокурор, өмгөөлөгч, хууль сахиулагч, эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, хамгаалах байранд үйлчилгээ үзүүлэгчид, асрамжийн газрын ажилтнууд, цэргийнхэн болон бусад мэргэжилтнүүдэд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон эрүү шүүлтийг бүрэн хориглох тухай асуудлаар, мөн тэрчлэн Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц, Хууль сахиулах албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль, Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд, Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмуудын талаар сургалт явуулах.

ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХ

- Газар чөлөөлөлт, дахин төлөвлөлтийн улмаас албадан нүүлгэхийг хориглох, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль зэрэг одоогийн хууль тогтоомжид албадан нүүлгэлтийн эсрэг хамгааллыг бэхжүүлэх болон НҮБ-ын Хөгжилд суурилсан нүүлгэлт, шилжилт хөдөлгөөний үндсэн зарчим, удирдамжид нийцүүлэх, баталгаажуулах;
- Орон байраар хангагдах эрхийн асуудлаар ажиллаж байгаа хүний эрх хамгаалагчдыг айлган сүрдүүлэлт, дарамт шахалтаас хамгаалах.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН БУСАД ЭРХ

- Орон байраар хангагдах эрх болон эдийн засаг, нийгэм, соёлын бусад эрхийг хамгаалсан олон улсын хүний эрхийн баримт бичиг, хэм хэмжээний талаар төрийн албан хаагчдад сургалт явуулах;

МОНГОЛ УЛС: ХҮНИЙ ЭРХИЙН БАЙДЛАА САЙЖРУУЛАХЫН ТҮЛД ИЛҮҮ ИХИЙГ ХИЙХ ЁСТОЙ
НҮБ-ЫН ЭЗЛЖТ ДҮГНЭЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛЭЭС ИЛГЭЭХ МЭДЭЭЛЭЛ
ЭДХ-ИЙН АЖЛЫН ХЭСГИЙН 36 ДУГААР ХУРАЛДААН, 2020 ОНЫ 11 САР
2019 ОНЫ 10 САРД ХЭВЛЭЖ, 2020 ОНЫ 7 САРД ШИНЭЧЛЭВ.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ

- Хүний эрх хамгаалагчийг таниулсан, хамгаалсан хууль баталж, хэрэгжүүлэх, хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаагаа хүний эрх хамгаалагчид явуулж чадаж байгааг баталгаажуулах;
- Хүний эрх хамгаалагчдын эсрэг гарч буй айлган сүрдүүлэлт, дарамт шахалт, халдлага, заналхийлэлд үр нөлөөтэйгээр анхаарал хандуулах, үүнд Хүний эрх хамгаалагчийн эсрэг үйлдэгдсэн зөрчил, хүчирхийллийг нэг бүрчлэн, яаралтай, хараат бусаар мөрдөн шалгах, гэм буруутай этгээдийг шударга шүүхээр шүүж, хохирогчдын зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг үр нөлөөтэйгээр барагдуулах;
- Тайван замаар эрхээ эдэлснийх нь төлөө эрүүгийн хэрэгт татах, бусад шүүхийн болон захиргааны арга хэмжээ авахаас татгалзах, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийг хүний эрх хамгаалагчдын дуу хоолойг хорих, дарамтлах зэргээр буруугаар хэрэглэхгүй байхыг баталгаажуулах;
- ТББ-ын тухай хуульд оруулж буй нэмэлт өөрчлөлт дэх иргэний нийгмийн байгууллагуудын санхүүжилтийн талаарх нөхцөл нь олон улсын хүний эрхийн үүрэг, амлалттай нь нийцсэн байх, иргэний нийгмийн байгууллагуудын аюулгүй байдалд хор хөнөөл, үйл ажиллагаанд саад тотгор учруулах зэргээр буруугаар хэрэглэгдэхгүй байхыг баталгаажуулах.

ДҮР ЗОРГООР ХОРИХ

- Баривчлагдсан, хоригдсон хэнд ч баривчилсан шалтгаан, хэргийн талаар нэн даруй мэдэгдэх, шүүгч буюу хуулийн дагуу шүүх эрх хэмжээ олгогдсон албан тушаалтанд нэн даруй шилжүүлэн, шударга шүүхийн хэм хэмжээнд бүрэн нийцсэн шүүхээр шийдвэрлэхийг баталгаажуулах;
- Эрх баригчдыг шүүмжлэх болон бусад хүний эрхийн асуудлаар ердөө тайван замаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлснийхээ төлөө хоригдож байгаа бүх хүнийг яаралтай, ямар ч болзолгүйгээр суллах.

ХАВСРАЛТ

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛЭЭС ГАРГАСАН ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД²³

Монгол улс: Цаазаар авах ялыг сэргээх санаачилгатай холбоотой нээлттэй захидал, 2017 оны 12 дугаар сарын 10, ASA 30/7324/2017

Монгол улс: НҮБ-ын шаардлага хангасан орон байраар хангагдах эрхийн асуудлаар Тусгай Илтгэгчид илгээх тайлан. 2017 оны 10 сарын 26, ASA 30/7341/2017

Монгол улс: Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноор цаазаар авах ял түүхэнд үлдлээ, 2017 оны 7 дугаар сарын 1, АСТ 50/6646/2017

Монгол улс: Хангалтгүй хэрэгжүүлж байна: Монгол улсын нийслэл Улаанбаатар хот дахь шаардлагатай орон байраар хангагдах эрх, 2016 оны 12 дугаар сарын 7, ASA 30/4933/2016


Монгол улс: Цаазаар авах ялыг халах түүхэн сонголт, 2015 оны 12 дугаар сарын 4, (хэвлэлийн мэдээ)


²³ Эдгээр бүх баримт бичиг Эмнести Интернэшнлийн цахим хуудас дээр байгаа: <https://www.amnesty.org/en/countries/asia-and-the-pacific/mongolia/>


**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ ДАЯН
ДЭЛХИЙН ХӨДӨЛГӨӨН.**


**НЭГ Л ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГДВӨЛ
ЭНЭ НЬ БИД БҮГДЭД ХАМААТАЙ.**

Холбоо барих

 info@amnesty.org
mongolia.amnesty@gmail.com

 +44 (0)20 7413 5500
+976 7000 4708

 www.facebook.com/AmnestyGlobal
[www.facebook.com/Amnesty International](http://www.facebook.com/AmnestyInternational)
Mongolia - Монголын Эмнести Интернэшнл

 @AmnestyOnline